

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Бүртгэл хөтлөх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, Маягт 1 /Мэдүүлгийн маягт/-ийг хоёрдугаар хавсралтаар, Маягт 2 /Үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаарх мэдээлэл/-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Батцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 214 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ч.УЛААН

Сангийн сайдын 2013 оны 11
дүгээр сарын 22-ны өдрийн 264
дүгээр тушаалын нэгдүгээр
хавсралт



БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь тендерт оролцохыг сонирхогч хуулийн этгээд, иргэний бүртгэлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх)-аас хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, тэдгээрийг мэдээллэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Яам нь худалдан авах ажиллагааны бүртгэл, мэдээллийн санг худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт шинжилгээний мэдээллийн систем /цаашид “систем” гэх/ (<http://pmmis.e-procurement.mn>)- ийг ашиглан энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон бүртгэж, мэдээллийн санг бүрдүүлнэ.

Хоёр. Бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт гаргах

- 2.1 Хуулийн этгээд, иргэн (цаашид “хүсэлт гаргагч этгээд” гэх) нь бүртгүүлэх хүсэлтээ энэ журмын хавсралт 1-д заасан мэдүүлэг болон нотлох баримтын хамт холбогдох яаманд хүргүүлнэ.
- 2.2 Энэхүү журмын 2.1-д заасан хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг ирүүлнэ.
 - 2.2.1 Мэдүүлэг /Хавсралт 1/;
 - 2.2.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар;
 - 2.2.3 Тусгай зөвшөөрлийн хуулбар;
 - 2.2.4 Шаардлагатай тохиолдолд төлөөлөх эрх бүхий этгээдийн итгэмжлэл;
 - 2.2.5 Үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаарх мэдээлэл /Хавсралт 2/;
 - 2.2.6 Албан ёсны хаяг /утас, факс, цахим шуудан гэх мэт/.
- 2.3 Энэхүү журмын 2.2-т заасан мэдээллийн үнэн зөвийг хүсэлт гаргагч этгээд бүрэн хариуцна.
- 2.4 Хүсэлт гаргагч этгээд нь энэ журмын 2.2.5-д заасан мэдээллийг ирүүлэхдээ дараах зүйлсийг хавсралт 2-т заасны дагуу тусгаж ирүүлнэ.

2.4.1 Ижил төстэй ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн туршлага;

2.4.2 Ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, техник, тоног төхөөрөмжийн жагсаалт.

2.5 Бүртгэгдсэн этгээдийн мэдээлэл өөрчлөгдсөн бол бүртгүүлсэн яаманд мэдэгдэнэ.

Гурав. Бүртгэл, мэдээллийн санд бүртгэх

3.1. Энэ журмын 2.1-д заасан хүсэлтийг системд нэвтрэх эрх бүхий яамны ажилтан, албан хаагч хүлээн авч бүртгэнэ. Шаардлагатай тохиолдолд хэрхэн бүртгэгдсэн талаарх мэдээллийг цахим хэлбэрээр хүсэлт гаргасан этгээдэд хүргүүлж болно.

3.2. Хүсэлтийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын дагуу бүртгэнэ.

3.3. Яам энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг архивын нэгж болгон хадгална.

3.4. Бүртгэгдсэн этгээдийн жагсаалтыг сар бүр Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-т нийтэлнэ.

3.5. Яам нь өөрийн мэдээллийн санд бүртгэгдсэн этгээдийн талаарх мэдээллийг захиалагчийн хүсэлтээр тухай бүр гаргаж өгнө.

3.6. Бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн нь тухайн этгээдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг илэрхийлэхгүй. Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн этгээдийн чадварын шаардлагыг нарийвчлан үнэлнэ.

3.7. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагааны бүртгэл, мэдээллийн санг хөтлөхөд мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангана.

Дөрөв. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх

4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4, 14.1.6, 14.1.7-д заасан нөхцөл үүссэнийг шүүх, худалдан авах ажиллагааны улсын байцаагч тогтоосон тохиолдолд тухайн тендерт оролцогчийг бүртгэлд хамруулах талаар улсын байцаагч санал гаргаж, худалдан авах ажиллагааны улсын ахлах байцаагчид танилцуулна.

- 4.2. Энэхүү журмын 4.1-д заасан саналыг гаргахдаа тендерт оролцогч, захиалагч байгууллагаас ирүүлсэн тайлбар, нотлох баримтыг харгалзан үзнэ.
- 4.3. Энэ журмын 4.1-д заасан нөхцөл байдал үүссэнийг тогтоосон улсын байцаагчийн санал болон шүүхийн шийдвэрийг үндэслэн Худалдан авах ажиллагааны ахлах байцаагч тухайн этгээдийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах саналыг Сангийн сайдад танилцуулна.
- 4.4. Энэ журмын 4.3-т заасан бүртгэлийг Сангийн сайдын тушаалаар албажуулна.
- 4.5. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг тухайн зөрчлийг гаргаснаас хойш 3 жилийн хугацаанд Засгийн газрын худалдан авах ажиллагаанд аливаа нэг хэлбэрээр оролцохыг хориглоно.
- 4.6. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулах шийдвэр гарсан даруй худалдан авах ажиллагааны улсын байцаагч тухайн этгээдэд уг бүртгэлд бүртгэгдсэн болохыг мэдэгдэнэ.
- 4.7. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn/-д энэ журмын 4.5-д заасан хугацаанд байршуулж олон нийтэд мэдээлж ажиллана.
- 4.8. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээд тендер шалгаруулалтад оролцож байгаа эсэхийг захиалагч болон үнэлгээний хороо Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn/-д байршуулсан мэдээллийг үндэслэн тендер шалгаруулалт тухай бүрт хянана.

Тав. Бусад

- 5.1 Бүртгэл мэдээллийн сангийн мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.
- 5.2 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Сангийн сайдын 2013 оны 11 дүгэр сарын 22-ны өдрийн 264 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



Маягт 1

МЭДҮҮЛГИЙН МАЯГТ

Дугаар ...

1. Хүсэлт гаргагчийн тухай мэдээлэл

1.1 Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн нэр:

.....

1.2 Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар /иргэн-иргэний үнэмлэхний хуулбар/.....

1.3 Төлөөлөх эрх бүхий этгээдийн овог, нэр.....

1.4 Төлөөлөх эрх бүхий этгээлийн РД.....

1.5 Хүсэлт гаргагчийн хаяг:

1.6 Утасны дугаар

1.7 Факсын дугаар:

1.8 Цахим шуудангийн хаяг.....

2. Хүсэлт гаргагчийн мэдүүлгийн зорилго /зөвхөн нэгийг тэмдэглэх/

2.1 шинээр бүртгүүлэх ()

2.2 бүртгэлээ шинэчлүүлэх ()

3. Эзэмшдэг тусгай зөвшөөрөл

3.1

3.2

3.3

4. Бүртгэгдэх үйл ажиллагааны төрлийг Сангийн сайдын 2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 103 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын дагуу доорх хүснэгтээр бүртгэнэ.

Салбар	Дэд салбар	Тодорхойлолт
А	01	Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа
	02	Ойн аж ахуй, мод бэлтгэл

Сангийн сайдын 2013 оны 11 дүгэр сарын 22-ны өдрийн 264 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

Маягт 2

Үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаарх мэдээлэл¹

БАРИЛГА УГСРАЛТ – F41

ӨМНӨ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТУРШЛАГА

Хүснэгт 1

Сүүлийн 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил, жилээр дараах хүснэгтийн дагуу жагсаах:

№	Төслийн нэр	Захиалагч, үйлчлүүлэгчийн нэр, холбоо барих ажилтан	Гүйцэтгэсэн ажлын төрөл, дууссан он	Гэрээний үнэ	Ерөнхий/түншлэл/туслан гүйцэтгэгчээр ажилласан
1					Ерөнхий гүйцэтгэгч
2					Туслан гүйцэтгэгч

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЧАДАВХИ

Хүснэгт 2

Хүсэлт гаргагч этгээдийн удирдах болон техникийн голлох мэргэжилтний чадвар, туршлага, /намтрыг хавсаргана/

№	Мэргэжил	Ажилласан жил (нийт)	Туршлага
1			
2			

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАДАВХИ

Хүснэгт 3

Хүсэлт гаргагч этгээдийн өөрийн үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ.

№	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр)	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг
1			
2			

¹ Үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаарх мэдээллийг харуулах хүснэгтүүдийг “Барилга угсралт” гэсэн төрлөөр жишээ болгон харуулав. Үйл ажиллагааны бүх төрлийн ангилал тус бүрийн хүснэгтийг салбарын яам тодорхойлж энд хавсаргана.